

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗДТГ-ЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН 7 ХОНОГИЙН АЖЛЫН ТАЙЛАН

**Тайлангийн хамрагдах хугацаа:** 2015-11-23-с 2015-11-27-ны хооронд

Хэлтсийн 10-н албан хаагчид төлөвлөгөөний дагуу ажлаа гүйцэтгэсэн байна.

### Төрийн сан

2015 оны 11 сарын 20-ноос 11 сарын 26-ны байдлаар төрийн сангийн төлбөр тооцооны FREEBALANC программаар төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данс, хөрөнгө оруулалтын данснаас 1,594,938,665.98 төгрөгийн 402 ширхэг гүйлгээ шивэгдсэн байна. ЗГСУМС-д шивэгдсэн 470 ш гүйлгээг хянан баталгаажуулж дамжуулсан.

Төрийн сангийн өдөр тутмын Мемориалын баримтыг 11-р сарын 20-ноос 11-р сарын 27 хүртэлх 5 өдрийн тайланг онлайн программаас хэвлэн авч Мемориалын программд шивж Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 11.5 –д заасны дагуу архивын баримт үүсгэж хянуулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны 11 сарын 16-наас 11 сарын 22-ны хооронд хийгдсэн 5 саяас дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээний жагсаалтыг гаргаж [www.khovsgol.gov.mn](http://www.khovsgol.gov.mn) сайтын шилэн дансны цэс болон мэдээллийн самбарт байршуулсан.

Хөвсгөл далай ээж нийгэмлэгт Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлж хариуцлагыг сайжруулах тухай аймгийн Засаг даргын 2013 оны А/313 тоот захирамжийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлын тайланг гаргаж хүргүүлсэн.

Аудитын газарт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулсан сургалтын талаарх мэдээллийг гаргаж хүргүүллээ.

Сангийн яамнаас тодруулахаар ирүүлсэн арилжааны банкин дахь дансны мэдээллийг аймгийн төв, сумдын байгууллагуудаас тодруулан нэтгэж Сангийн яаманд хүргүүллээ.

Түнэл сумын төрийн сангийн мэргэжилтний Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд нэвтрэх эрх олгох хүсэлтийг Сангийн яамны төрийн сангийн газарт уламжилсан.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үзлэг явуулах удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан сумдад болон аймгийн төвийн төсөвт байгууллагуудад хүргүүллээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн талаар аймгийн ИТХ-д оруулах илтгэл, слайдыг бэлтгэсэн.

Сумдад санхүүгийн дэмжлэг 909,0 сая хуваарилсан.

Нэмэлт төсвийн эрх нээлгэх хүсэлт ирүүлсэн 35 байгууллагын хүсэлтийг нэгтгэн Сангийн яаманд явуулж нээлгэлээ.

ОНХСанд ирсэн орлогын шилжүүлгийн 155,9 сая төгрөгийг сумдад хуваарилсан.

Замын сангийн гүйлгээ хийсэн.

Аймгийн ЗДТГ-ын хаагдсан эрхүүдийг нээлгэх хүсэлт Сангийн яаманд гаргаж шийдвэрлүүлсэн.

### **Төсөв:**

Аймгийн 2016 оны төсвийн төслийг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн 2016 оны төсвийн төслийг 2015 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Аймгийн ИТХ-д өргөн барьлаа.

Аймгийн 2016 оны төсвийн төслийг Аймгийн ИТХ-ын төсөв, санхүү, эдийн засгийн байнгын хороо, Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэн, гарсан санал дүгнэлтийн дагуу өөрчлөлтийг төсөвт тусган, материалыг хэвлэж Аймгийн ИТХ-д хүргэх ажлыг зохион байгуулж байна.

2016 оны төсөв батлах аймгийн ИТХ-ын хуралдаан 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр болно.

## **САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС**